

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/111/СТА-ТШЗ

Баянхонгор хот. 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 7044-2584      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 7044-2424      Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345      Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1.	Оршил .....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал .....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮҮХДИЙН  
ТЭМҮЖИН ТЕАТРЫН ТӨСВИЙН  
ЗАХИРАГЧ Б.ГАНЧИМЭГ ТАНАА

2019.02.25 № 2/105  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох

2519196

бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### **Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн захирагч Б.Ганчимэгт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.23-наас 2019.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б. Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театр 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театр нь “Мэргэжлийн чадварлаг боловсон хүчинтэй, чанартай үйлчилгээ таатай орчинд тулгуурлаж үзэгчид суралцагч хүүхдүүдийн эрэлт хэрэгцээг хангаж хүүхдийн авъяас чадварыг нээн хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

- Соёлын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 42 оноотой үнэлэгдсэн тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзэж аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театр санхүүгийн тайланг бэлтгэхдээ "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Acolous 4.01, цалингийн Payroll" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театр дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үр нөлөөгүй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 323319,1 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 6466,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцөлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

### Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	1.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	0.10	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	1.10	

### **2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### **2.8.1.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

Анхан шатны баримтыг тулган шалгахад Н.Оюунчимэг томилолтоор ажиллаагүй байхад 36,0 мянган төгрөг олгосон, хувь хүнээс суутгасан 50,0 мянган төгрөгийн татварын орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, 2018 оны 10 дугаар сард ажилтан Ц.Есөн-Эрдэнээс НДШ-ийн 49347 төгрөгийг суутган тооцоогүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоов.

### **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Бараа материалын тайлан гаргалт, түүний бүртгэлийг үнэн зөв хийхэд анхаарах шаардлагатай.

### **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 312752,2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 312202,1 мянган төгрөг буюу 99,7 хувьтай байгаа нь бусад зардлыг хэмнэж, оны эцэст 550,1 мянган төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоор 25740,0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө өгснийг 100% биелүүлж ажиллажээ.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театр Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

2018 оны 1-9 сарын шилэн дансны мэдээллийг 2018 оны 11 дүгээр сард хийсэн нийцлийн аудитаар шалгасан байна. Санхүүгийн тайлангийн аудитаар 10-12 сарын мэдээллийг шилэн дансанд байршуулсныг шалгахад 10-11 сарын тушаалын хэвлэмэл хуудсанд гаргаагүй 2 шийдвэрийг байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитыг “Глобал капитал” ХХК гүйцэтгэж, 2 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 70 хувьтай байна.

### ӨМНӨХ АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

дд	Өмнөх аудитаар илэрсэн зөрчил	Өгөгдсөн зөвлөмж	Хэрэгжилт	Биелэлт
1	Бараа материалын орлогыг бүртгэхдээ дансны эдийн засгийн ангиллыг буруу хийсэн.	НББОУС-ийн үзэл баримтлалын 33 дугаарт "Мэдээлэл итгэл үнэмшилтэй байхын тулд ажил гүйлгээ үйл явцыг үнэн зөв тусгах ёстой" гэсэн НББ-ийн нийтлэг зарчмыг хэрэгжүүлж ажиллах	Зарим сарын тайланг зөрүүтэй илэрхийлсэн.	90%
2	НББ-ийн нийтлэг зарчмыг мөрдөж ажиллаагүй.	Сангийн сайдын 388-р тушаалаар батлагдсан дансны зааврыг мөрдөж ажиллах, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах	Сангийн сайдын 388 тоот тушаалыг мөрдөж ажиллаагүй, батлагдсан төсвийг_ зориулалтын дагуу зарцуулсан байна.	50%
Биелэлт хувь			-	70%

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Зардлын данстай холбоотой асуудал

##### 3.1.1 Илрүүлэлт:

Цагийн тооцоог бодохдоо тухайн сарын ажлын хоногийг буруу тооцдог, үүний улмаас ээлжийн амралтын нөхөн олговор бодохдоо ажлын өдрийг буруу тооцсон байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалтыг зөрчсөн байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Ээлжийн амралтын нөхөн олговрын тооцоолол буруу байх

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

**Тухайн сарын ажлын өдрийг зөв тооцож цалинг олгож, цалингийн цэстийн өдрийг үндэслэн ээлжийн амралтын нөхөн олговрыг бодох**

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

#### 3.2 Балансын данстай холбоотой асуудал

##### 3.2.1 Илрүүлэлт:

Кассын орлогыг бүртгэхдээ кассад байгаа бэлэн мөнгөөр бүртгээгүй, өглөгөөр бүртгэсэн. Ажиллагсдад олгосон томилолтын урьдчилгааг авлагаар бүртгэлгүй, өглөгөөр бүртгэсэн.

Тайлант онд 1044200 төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Хэмжилт, үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан зааврыг зөрчсөн байна.

### 3.2.2 Эрсдэл:

Дансны бичилтийг буруу хийсэн байх

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

**Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврыг мөрдөж, алдааг давтан гаргахгүй ажиллах, кассын тайланг үнэн зөв тайлагнах**

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

### 3.3.1. Илрүүлэлт:

Няrvын гаргасан тайлан санхүүгийн тайлангаас зөрүүтэй бэлтгэгдсэн байна.

### 3.3.2. Эрсдэл:

Бараа материалын тайлан буруу илэрхийлэгдэх

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

**Ашиглалтнаас гарсан бараа материалыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн баримтжуулан акталж, бүртгэлээс хасах**

### 3.4.1. Илрүүлэлт:

Татварын сайтнаас авсан мэдээгээр 2017 оны эцэст хувь хүнээс суутгасан орлогын албан татварын авлага 478000, цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын 178493 төгрөгийн авлагатай, оны эцэст эдгээр татварын 561365 төгрөгийн авлагатай байхад санхүүгийн тайланд тус авлагыг тусгаагүй байна. Татварт 2018 оны цалингийн санг 960374 төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн, татавын мэдээгээрх ногдуулалт, ажилчдаас суутгасан татвар, татварт шилжүүлсэн татвар зөрүүтэй байна.

Энэ нь Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг зөрчсөн байна.

### 3.4.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд авлага, өглөг дутуу бүртгэсэн байх

### 3.4.3 Өгсөн зөвлөмж:

**Татварын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн цалинг залруулж, татварын авлага, өглөгийн тооцоог дахин нягталж, 2019 онд авлага, өглөггүй ажиллах**

### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 05 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/Төгрөгөөр/	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>75,504,394.00</b>	<b>82,986,239.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	16,145.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	16,145.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	75,504,394.00	82,970,094.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	5,799,190.00	6,955,690.00
35110	Тусгай зориулалттай материал	5,799,190.00	6,955,690.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	69,705,204.00	76,014,404.00
35410	Бичиг хэргийн материал	185,100.00	185,100.00
35420	Аж ахуйн материал	5,356,100.00	5,378,100.00
35450	Барилгын засварын материал	14,860.00	14,860.00
35470	Бусад хангамжийн материал	64,149,144.00	70,436,344.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>38,756,567.01</b>	<b>30,746,108.64</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	38,756,567.01	30,746,108.64
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	34,995,467.01	26,985,008.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	102,448,631.00	103,648,631.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	100,605,491.73	101,418,928.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	109,988,196.00	109,988,196.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-79,365,593.15	-87,391,115.16
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,824,500.00	2,824,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-489,775.11	-861,275.19
39217	Ном	195,000.00	195,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3,761,100.00	3,761,100.00
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-750,000.00	-750,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,761,100.00	3,761,100.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>114,260,961.01</b>	<b>113,732,347.64</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>417,440.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	417,440.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	417,440.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>114,260,961.01</b>	<b>113,314,907.64</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	114,260,961.01	113,314,907.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	137,949,437.69	137,949,437.69
51101	Өмч: - төрийн	137,949,437.69	137,949,437.69
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-46,789,837.68	-47,735,891.05
51210	Өмнөх үеийн үр дүн	-46,789,837.68	-46,789,837.68
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-946,053.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,101,361.00	23,101,361.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>114,260,961.01</b>	<b>113,732,347.64</b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>306,519,850.00</b>	<b>321,936,108.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>25,000,750.00</b>	<b>25,740,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	25,000,750.00	25,740,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,000,750.00	25,740,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,000,750.00	25,740,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,000,000.00</b>	<b>9,183,908.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	276,519,100.00	287,012,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	5,000,000.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	8,000,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	00.00	1,183,908.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	1,183,908.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>317,096,648.38</b>	<b>322,882,161.37</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>317,096,648.38</b>	<b>322,882,161.37</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	313,102,843.14	319,833,152.27
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	172,421,928.31	177,726,174.86
210101	Үндсэн цалин	172,421,928.31	177,726,174.86
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,364,062.45	21,550,109.04
210201	Тэтгэврийн даатгал	19,364,062.45	20,928,414.04
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	155,424.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	124,339.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	31,085.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	310,847.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	70,221,172.00	79,217,990.00
210301	Гэрэл, цахилгаан	1,711,880.00	2,150,668.00
210302	Түлш, халаалт	62,300,700.00	70,464,250.00
210303	Цэвэр, бохир ус	6,208,592.00	6,603,072.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,126,992.00	3,277,575.00
210401	Бичиг хэрэг	747,100.00	879,569.00
210402	Тээвэр, шатахуун	2,078,600.00	1,034,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	398,522.00	438,306.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	260,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,662,770.00	665,250.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	170,000.00	520,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	170,000.00	520,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,006,650.00	1,341,570.00
210604	Урсгал засвар	1,006,650.00	1,341,570.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,420,000.00	2,946,000.00
210701	Гадаад албан томилолт		00.00
210702	Дотоод албан томилолт	1,420,000.00	2,946,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	29,132,340.00	24,043,275.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,823,340.00	23,743,275.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	188,000.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	121,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,239,698.38	9,210,458.37

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,239,698.38	9,210,458.37
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,000,000.00</b>	<b>3,049,009.10</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,000,000.00</b>	<b>2,498,908.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	1,183,908.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,315,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>550,101.10</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	550,101.10
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-10,576,798.38</b>	<b>-946,053.37</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-10,576,798.38</b>	<b>-946,053.37</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>306,519,850.00</b>	<b>321,936,108.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>25,000,750.00</b>	<b>25,740,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	25,000,750.00	25,740,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	25,000,750.00	25,740,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,000,750.00	25,740,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>281,519,100.00</b>	<b>296,196,108.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	276,519,100.00	287,012,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,000,000.00</b>	<b>8,000,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	8,000,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>1,183,908.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	1,183,908.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>306,519,850.00</b>	<b>321,936,108.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>306,519,850.00</b>	<b>321,936,108.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>299,506,044.76</b>	<b>319,652,098.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>172,032,787.90</b>	<b>177,637,258.86</b>
210101	Үндсэн цалин	172,032,787.90	177,637,258.86
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,897,810.86</b>	<b>21,463,170.04</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,897,810.86	18,426,501.04
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	769,027.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	345,076.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	167,609.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,754,957.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>70,421,564.00</b>	<b>78,809,000.00</b>

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	1,912,272.00	2,150,668.00
210302	Түлш, халаалт	62,300,700.00	70,055,260.00
210303	Цэвэр, бохир ус	6,208,592.00	6,603,072.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,262,992.00</b>	<b>3,348,100.00</b>
210401	Бичиг хэрэг	747,100.00	888,193.00
210402	Тээвэр, шатахуун	1,078,600.00	1,028,851.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	398,522.00	460,306.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	260,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,798,770.00	710,750.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>170,000.00</b>	<b>520,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	170,000.00	520,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,994,500.00</b>	<b>1,902,570.00</b>
210604	Урсгал засвар	1,994,500.00	1,902,570.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,420,000.00</b>	<b>2,672,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,420,000.00	2,672,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>30,306,390.00</b>	<b>33,300,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,997,390.00	33,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	188,000.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	121,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,000,000.00</b>	<b>2,284,009.10</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,000,000.00</b>	<b>1,733,908.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	1,183,908.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	550,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>550,101.10</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	550,101.10

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-46,789,837.68	114,260,961.01
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-46,789,837.68	114,260,961.01
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-946,053.37	-946,053.37
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-47,735,891.05	113,314,907.64

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	269,519,100.0	269,505,295.8	312,752,200.0	312,202,098.9
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	269,519,100.0	269,505,295.8	318,202,200.0	312,202,098.9
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	00.0	00.0	312,202,200.0	311,652,098.9
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	172,158,000.0	172,032,787.9	177,637,300.0	177,637,258.9
210101	Үндсэн цалин	172,158,000.0	172,032,787.9	177,637,300.0	177,637,258.9
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	18,937,400.0	18,897,810.9	22,013,200.0	21,463,170.0
210201	Тэтгэврийн даатгал	12,025,870.0	00.0	14,337,300.0	18,426,501.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,382,340.0	00.0	2,331,500.0	769,027.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,727,950.0	00.0	1,425,200.0	345,076.0
210204	Ажилгүйдлийн даатгал	345,600.0	00.0	356,300.0	167,609.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,455,640.0	00.0	3,562,900.0	1,754,957.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	69,940,260.0	70,421,564.0	78,809,000.0	78,809,000.0
210301	Гэрэл, цахилгаан	1,988,860.0	1,912,272.0	3,331,100.0	2,150,668.0
210302	Түлш, халаалт	61,741,800.0	62,300,700.0	68,675,300.0	70,055,260.0
210303	Цэвэр, бохир ус	6,209,600.0	6,208,592.0	6,802,600.0	6,603,072.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,593,000.0	4,262,992.0	3,348,100.0	3,348,100.0
210401	Бичиг хэрэг	1,276,300.0	747,100.0	1,109,900.0	888,193.0
210402	Тээвэр, шатахуун	1,037,300.0	1,078,600.0	1,037,300.0	1,028,851.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	399,400.0	398,522.0	384,000.0	460,306.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.0	240,000.0	79,500.0	260,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,640,000.0	1,798,770.0	737,400.0	710,750.0
2105	<b>Нормативт зардал</b>	170,000.0	170,000.0	520,000.0	520,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	170,000.0	170,000.0	520,000.0	520,000.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,944,800.0	1,994,500.0	1,902,600.0	1,902,570.0
210604	Урсгал засвар	1,994,800.0	1,994,500.0	1,902,600.0	1,902,570.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,420,000.0	1,420,000.0	2,672,000.0	2,672,000.0
210702	Дотоод албан томилолт	1,420,000.0	1,420,000.0	2,672,000.0	2,672,000.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	309,000.0	309,000.0	25,300,000.0	25,300,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.0	00.0	25,000,000.0	25,000,000.0

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	188,000.0	188,000.0	300,000.0	300,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	121,000.0	121,000.0	00.0	00.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	00.0	00.0	550,000.0	550,000.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.0	00.0	550,000.0	550,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.0	00.0	550,000.0	550,000.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	269,522,460.0	269,508,654.8	312,752,200.0	312,202,098.9
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		00.0	287,012,200.0	286,462,098.9
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	269,522,460.0	00.0	287,012,200.0	286,462,098.9
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	25,740,000.0	25,000,750.0	25,740,000.0	25,740,000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,740,000.0	25,000,750.0	25,740,000.0	25,740,000.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	20.0	25.0	20.0	25.0
620001	Удирдах ажилтан	01.0	01.0	01.0	01.0
620002	Гүйцэтгэх ажилтан	15.0	20.0	15.0	20.0
620003	Үйлчлэх ажилтан	04.0	04.0	04.0	04.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>20.0</b>	<b>25.0</b>	<b>20.0</b>	<b>25.0</b>
650006	Соёл урлагийн салбарын терийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	13.0	18.0	13.0	18.0
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	07.0	07.0	07.0	07.0